



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалт, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дийг Ай Ти" ХХК-д 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд зохион байгуулагдах "Бизнес шинжилгээний сургалт"-д Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны Программ хангамж хөгжүүлэлтийн хэсгийн ахлах инженер Б.Шинэбаатар, программ хангамжийн инженер Б.Батбилэг, Д.Ган-Өлзий, Н.Лхагвасүрэн, системийн шинжээч мэргэжилтэн Б.Өлзийцэцэг, өгөгдлийн сангийн шинжээч мэргэжилтэн Ө.Мичидмаа нарыг хамруулсугай.

2. Сургалтын төлбөрт 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтад хамрагдах ажилтнуудын ажил үүрэгт нь зохицуулалт хийж, сургалтын үр дүнд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн аюулгүй байдал, технологийн алба (Г.Цэвээнгэрэл)-нд, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн дотор тайлагнахыг Б.Шинэбаатар, Б.Батбилэг, Д.Ган-өлзий, Н.Лхагвасүрэн, Б.Өлзийцэцэг, Ө.Мичидмаа нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0422